Д.НАСАНБАТ

МҮИС-ийн Хууль зүйн ухааны сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн ахлах багш

ТОРГОХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Хураангуй

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр бүлэгт хуульчилсан "Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа" институтын хүрээнд шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчээс шүүхийн шийдвэр, тогтоолыг албадан биелүүлэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж буй хэдий ч улсын хэмжээнд шийдвэр гүйцэтгэлийн, тэр дундаа торгох ялын бодит биелэлт шаардлагын түвшинг хангахгүй байна. Иймээс торгох ял эдлүүлэх ажиллагааг шуурхай гүйцэтгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийг дээшлүүлэх, боловсронгуй болгох асуудлыг онолын болон практикийн хүрээнд судалж, дүгнэлт хийх зайлшгүй шаардлага гарч байна.

Торгох ял, ялын тухай ерөнхий ойлголт

Ял нь эрүүгийн хариуцлагын нэгэн төрөл бөгөөд гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр нотлогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын онцгой арга хэмжээ юм. Ял нь төрийн бусад албадлагаас дараах шинжээрээ ялгагдана:

-Ялыг төрийн нэрийн өмнөөс шүүх шийтгэх тогтоолоор оногдуулна.

-Ял нь бусад албадлагаас илүү хүнд цээрлэлийг өөртөө агуулна.

-Ялын төрөл хэмжээг зөвхөн эрүүгийн хуулиар тогтоож, түүнд заасан зарчим, журмыг баримтлан оногдуулна.

-Ял нь ялтай байдлыг бий болгоно.

-Ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэглэдэг хувийн шинжтэй арга хэмжээ.

-Ялын биелэлтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцна.

Ял нь төрийн албадлагын хамгийн хатуу хүнд хэлбэр юм.

Орчин үед хүний эрх, эрх чөлөөг хасахаас аль болохоор татгалзаж, хорихоос өөр төрлийн ял буюу эд хөрөнгийн шинжтэй ялыг илүү сэргээхэд чиглэгдэж эхэлсэн бөгөөд ялын төрөл цөөн байх хандлага хүчтэй болж байгаагийн илрэл нь нийгэмд үйлчлэх ял буюу торгох ялыг ялын тогтолцоонд оруулсан явдал юм.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ. Энэ ялыг дэлхий нийтийн хэмжээнд үндсэн ял болгон түгээмэл хэрэглэгддэг бөгөөд хэрэг үйлдсэн этгээдийн эдийн засгийн эрхэнд нь халдаж тодорхой хэмжээний гачигдал учруулдаг тул цээрлүүлэх агуулгын механизм нь материаллаг шинжтэй байдаг. Торгох

ял нь Монгол Улсын эрүүгийн ял шийтгэлийн тогтолцоонд нэлээд байр суурийг эзлэх, хамгийн хөнгөн төрлийн ял бөгөөд 2002 оны Эрүүгийн хуулиас өмнөх хуулиар торгох ялын хэмжээг тодорхой заан хуульчилж байсан бол 2002 оны хуулиар торгох ялын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тооцож тогтоохоор заасан ба энэ нь өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдэгдэх үед мөрдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтооно. Торгуулсан этгээдийн эдийн засгийн эрхээс өөр эрхэнд энэ ял халдахгүй учир нийгэм хамт олны дунд байж хүмүүжих боломжийг олгодог хөнгөн төрлийн ял юм.

Эрүүгийн хуульд хорих, торгох санкцтай 33 зүйл анги, баривчлах, торгох санкцтай 77 зүйл анги тус тус байдаг байна.

Торгох ял нь дараахь шинжүүдтэй:

-Торгох ялыг нэг удаа л хэрэгжүүлнэ.

-Хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэглэнэ.

-Ялтны материаллаг эрх ашгийг л хөндөнө.

Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялыг баривчлах, гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар солих талаар Эрүүгийн хуульд хуульчлан заасан байдаг билээ.

Торгох ялыг биелүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт

Торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 91 дүгээр зүйлд заасны дагуу болон энэ хуулийн 10-14, 18-20 дугаар зүйлүүдэд зааснаар тухайлбал, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын хохирол болон төлбөрийг барагдуулах ШГА-ны нэгэн адил явагдана гэж ойлгож болно.

Улсын хэмжээнд сүүлийн 5 жилд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлэгчдийн дотор торгох ял 25-28%-ийг эзэлж байна.[143]

Хорихоос өөр төрлийн ЯЭА нь хэдийгээр эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийтгэх тогтоол гүйцэтгэх ажиллагааны дагуу явагдах боловч торгох, эд хөрөнгө хураах ял нь иргэний хэргийн ШГА-ны нэгэн адил гүйцэтгэдэг байна. Өөрөөр хэлбэл торгох, эд хөрөнгө хураах ял нь эрүүгийн хэргийн талаарх шүүхийн ШГА-нд хамаардаг ч эрх зүйн зохицуулалтын хувьд баримтлах зарчим нь иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд холбогдох зарчимтай адил байдаг.

Торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг ялтан 7 хоногийн дотор сайн дураар биелүүлэх үүрэгтэй бөгөөд заасан хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй тохиолдолд шүүгч шийтгэх тогтоолыг ялтны оршин суугаа буюу ажиллаж байгаа, эсхүл эд хөрөнгө нь байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд 3 хоногийн дотор хүргүүлэх ба тухайн шийдвэр гүйцэтгэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэх

баримт бичгийн агуулга, түүнд тавигдах шаардлага, үр дагаврыг тооцон үндэслэлтэй гэж үзвэл хувийн хэрэг нээж, гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор ШГА-г үүсгэх тогтоол гарган зохих тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна. Шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор торгуулийн мөнгийг шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд тушаах, уг хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй бол ялыг албадан биелүүлэх тухай ялтанд мэдэгдэх хуудас явуулна.

Ялтан торгуулийн мөнгийг бүрэн тушааснаар торгох ялыг бодитой биелүүлсэнд тооцож, шийдвэр гүйцэтгэгч энэ тухай шийдвэр гаргасан шүүхэд мэдэгдэж гүйцэтгэх баримт бичгийг архивт шилжүүлнэ. Хэрэв ялтан торгуулийн мөнгийг 14 хоногийн дотор төлөх бололцоогүй байвал түүний өргөдлийг үндэслэн шийдвэр гүйцэтгэгч торгуул төлөх хугацааг 6 сар хүртэл хугацаагаар хойшлуулах болон мөн хугацааны дотор хэсэгчлэн төлүүлэх тухай санал прокурорт гаргах ба прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Хорихоос өөр төрлийн ЯЭА нь хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаж байгаа эсэхэд Улсын Ерөнхий прокурор, түүний харьяа прокурор хяналт тавихаар тус тус заасан байдаг.

Прокурорын байгууллага нь шүүхээс хорих болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтны ял эдлэлтийн байдалд хяналт тавьж, ЯЭА-тай холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, хорих болон шүүхийн ШГА байнгын тасралтгүй байх зарчим хэрхэн биелэгдэж байгаад хяналт тавих үндсэн үүргийг гүйцэтгэн ажилладаг.

Торгох ял биелэхгүй байгаа шалтгаан нөхцлийг судлахад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд болон шүүхээс эд хөрөнгө, цалин орлого, ажил хөдөлмөр эрхэлдэг эсэхийг нь тогтоогоогүй ял оноосон, голдуу зам тээврийн осол гаргасан этгээдүүдэд оногдуулсан ба жолооч нар нь өөрсдөө давхар хүнд хүндэвтэр гэмтэлтэй тул хөдөлмөр эрхлэж торгуулийн ялыг биелүүлэх боломжгүй иргэдэд оногдуулсан байна. Мөн эд хөрөнгө хураах, торгох ял шийтгэлтэй гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагааны явцад ялтны өмч хөрөнгийг нарийвчлан шалгаж тогтоох, битүүмжлэх ажиллагаа хийгээгүйн улмаас шүүхээс оногдуулсан хэт өндөр торгох ял биелэгдэхгүй байх үндэс суурь болж байна. Хорихоос өөр төрлийн ЯЭА-г гүйцэтгэж буй аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албад хууль тогтоомжийн заалтыг хэрхэн биелүүлж байгаа талаар хийсэн шалгалтын материалтай танилцаж, ял эдлүүлэх явцад шийдвэр гүйцэтгэгч нарын гаргаж буй нийтлэг зөрчил, дутагдлуудыг нэг бүрчлэн авч үзвэл:

- Шийтгэх тогтоол, гүйцэтгэх хуудсыг хүлээн авмагц, хуульд заасан хойшлуулшгүй ажиллагааг хийхгүй цаг хугацаа алддаг, төлбөрийг албадан биелүүлэх тухай мэдэгдэх хуудсыг ялтанд гардуулдаггүй;
- Тойргийн харьяаллаар шилжиж буй гүйцэтгэх баримт бичгийн бүртгэл хөтөлдөггүй, хэнд хэзээ шилжүүлсэн нь

тодорхойгүйгээс хэний үйл ажиллагаанаас болж хэн хариуцлагагүй ажилласныг тогтооход бэрхшээлтэй;

- Ялаас зайлсхийсэн ялтныг ял солиулах талаар санал гаргадаггүйн зэрэгцээ ял солиулахаар санал хүргүүлж буй материал хангалтгүй, зайлсхийсэн үндэслэлийг тогтоосон баримтын бүрдэл дутуу;

- Өндөр үнийн дүнтэй торгох ялыг хэсэгчлэн гүйцэтгэж буй тохиолдолд төлбөрийн чадваргүй байдлыг тогтоосон эсэх талаар огт баримт байхгүй атал хэсэгчлэн гүйцэтгэж буй нэрийн дор ялтанд ял завшуулдаг;

-Ялтны шийтгэх тогтоол, гүйцэтгэх хуудсыг шүүхээс хүлээн аваад хувийн хэрэг нээдэггүй, ямар ч ажиллагааг хийхгүй дардаг;

-Эрэн сурвалжлах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулдаггүй, цагдаагийн байгууллагад албан бичиг хүргүүлснээр ШГА-г хязгаарладаг, хуульд заасан хойшлуулшгүй ажиллагааг явуулдаггүй, үндэслэлгүйгээр түдгэлзүүлдэг зэрэг зөрчлүүд ШГА-ны явцад илэрсэн байна.

<u>Торгуулийн ялын бодит биелэлтээс дурдвал</u>

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорихоос өөр төрлийн ял /торгох ял/ оногдуулснаар 2009-2012 оны байдлаар улсын төсөвт 2.7 **тэрбум** төгрөгийг бодитойгоор төвлөрүүлсэн.[144]

Үүнээс үзэхэд хорихоос өөр төрлийн ял нь нийгэм, эдийл засгийн хувьд ач холбогдолтойн зэрэгцээ ялтныг нийгэмд нийгэмшүүлэхэд онцгой үүрэгтэй юм. Аймаг, нийслэлийн торгуулийн ялын бодит биелэлтийг сүүлийн 4 жилээр харахад төлүүлсэн байгаа байдал нь туйлын хангалтгүй байх бөгөөд **2012 оны үлдэгдэл 74 гүйцэтгэх баримт бичгийн 569.2 сая төгрөгийн** төлбөр бүхий торгох ялын төлбөр он, он дамжин гүйцэтгэгдэх болж байна. Мөн торгох ялаар шийтгэгдсэн төлбөр төлөгч /ялтан/ нь бодит амьдрал дээр дийлэнх нь өөрт ногдох хөрөнгө орлогогүй буюу төлбөрийн чадваргүй болох нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тогтоогдсон байна. Нийт торгох ял шийтгүүлэгсдийн 60-80 орчим хувь нь хөрөнгө, орлогогүй, төлбөрийн чадваргүй ялтан байдаг байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан сүүлийн 5 жилийн судалгаанаас үзэхэд:

-Баян мөнгөтэй хүмүүсийн хувьд хөнгөн ял;

-Торгох ялыг хуулийн цоорхой болгон ялт этгээдад ял завших боломж гэж үздэг;

-Мөнгө бага боломж тааруу хүмүүст хүнд ял гэж тус тус үздэг байна.[145];

Гэм буруутай этгээдийн эд хөрөнгийн байдлыг харгалзах нь уг ялыг зөв хэрэглэх, биелэлтийг нь хангах чухал нөхцөл мөн. Өнөөдөр шүүхүүд торгох ялыг оновчтой зөв сонгон хэрэглэж чадахгүй байгаагаас

---

[144] Жишээ баримт "Торгох ялын бодит биелэлтийн мэдээ-Шийдвэр гүйцэтгэх газрын 2009-2012 статистик үзүүлэлт"-ээс

[145] http/www.tugal.blog.go.mn/read/entry434496. 2012.

ялын биелэлтийг хангаж чадахгүйд хүрч байна. Энэ нь торгох ялыг бусад төрлийн ялаас сонголт хийхийн өмнө гэм буруутай этгээдийн эд хөрөнгийн байдлыг харгалзан үзэхгүй байгаатай шууд холбоотой юм. Зарим шүүгчид ялтны эд хөрөнгийн байдлыг харгалзаж, төлбөрийн чадварийн байдалд дүгнэлт хийхгүй торгох ял оногдуулж байгаа нь уг ялыг биелүүлэх боломжгүй байдалд оруулж байгаа төдийгүй торгуулийн мөнгөө олохын тулд арга буюу дахин гэмт хэрэг шинээр үйлдэхэд хүргэхийг үгүйсгэх аргагүй юм.

2013 оны эхний 8 сарын байдлаар:

-Торгох ялаар шийтгүүлсэн 223 ялтанд холбогдох 1212560.6 мянган төгрөгийн гүйцэтгэх баримт бичигт ШГА явуулж, 160 ялтанд холбогдох 736233,2 мянган төгрөгийг бүрэн биелүүлж, 63 ялтны 476327,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бодит биелэлт гүйцэтгэх хуудас 71,7 хувь, мөнгөн дүн 60,7 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бодит биелэлт гүйцэтгэх хуудас 15 хувиар, мөнгөн дүн 12,5 хувиар тус тус өссөн байна. Сүүлийн 3 жилийн дундажтай харьцуулахад 22,2 хувиар өссөн байна.[146]

Харин Шүүхээс торгох ял оногдуулсан 2007 оноос хойших мэдээ, судалгаанаас үзэхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн ихэнх зүйл, заалтын санкцид байдаг торгох ял оногдуулсан байдал жил тутам буурч ирсэн байх юм.

Торгох ялын бодит биелэлтийн дүнгээс

№	Он	Үзүүлэлт	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Биелэлтийн хувь
1	2009	Гэмт хэргийн тоо	431	235	54.5
		Дүн ₮	2218751.6	1224217.1	55.1
2	2010	Гэмт хэргийн тоо	182	126	69.2
		Мөнгөн дүн	765781.5	285470.7	37.3
3	2011	Гэмт хэргийн тоо	248	131	52.8
		Мөнгөн дүн	1241785	404827.3	32.6
4	2012	Гэмт хэргийн тоо	237	160	67.5
		Мөнгөн дүн	1035489.5	736233,2	71.1

Гэтэл торгох ялаар шийтгэгдсэн этгээд төлбөрийн чадваргүй байх, торгуулийн ял хэт өндөр байх гэсэн 2 үндэслэлээр торгох ялыг биелүүлэхэд ихээхэн хүндрэл учирч байна.

Жишээ баримт: Сүхбаатар аймгийн Сум дундын шүүхийн 2011 оны 9-р сарын 10-ны өдрийн 83 дугаар шийтгэх тогтоолоор Баруун-Урт сумын 4-р багийн иргэн С овогтой Ц-г

[146] Улсын Дээд Шүүхийн мэдээлэл. Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл I дэвтэр УБ., 2006 он 144 тал

17.595.000 төгрөгөөр торгож шийтгэжээ.

Хэргийн байдлаас үзэхэд ялтан Ц нь Хятад улсад үйлдвэрлэсэн бага оврын ТТ-25 маркийн трактороор хог зөөж амьдардаг байсан бөгөөд хог зөөх явцдаа чиргүүл дээр нь сууж явсан хүн унаж нас барсан байна. Гэтэл шүүхээс түүнд 17.595.000 төгрөгөөр торгож шийтгэсэн нь биелэгдэх боломжийн хувьд туйлын хангалтгүй юм. Учир нь ялтан Ц нь 4-р багт ам бүл-7, эрхэлсэн тодорхой ажилгүй тус багийн нэн ядуу өрхийн бүртгэлд ордог болох нь ШГА-ны явцад тогтоогдсон байна.

Мөн насанд хүрээгүй этгээд торгох ялаар шийтгэгдсэн нөхцөлд түүний торгуулийн мөнгийг хэн төлөх вэ? гэдэг асуудал практикт ихээр гарч ирж байна. Насанд хүрээгүй этгээд нь ямар нэг орлогын эх үүсвэр байхгүй бөгөөд түүний торгуулийн мөнгийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар нь төлөхөөс өөр аргагүй байдалд хүрч байгаа бөгөөд ял шийтгүүлсэн этгээдийн гэр бүлийн гишүүд ч гэсэн уг шийтгэлийг давхар эдэлж байна гэсэн үг.

Шүүхээс торгох ялыг гэм буруутай тодорхой нэг этгээдэд оногдуулж байгаа хэдий боловч уг торгох ял нь амьдрал дээр тухайн ялтны гэр бүлийн гишүүдийг бүхэлд нь хамарч байгаа бөгөөд өөрөөр хэлбэл гэр бүлийн бүх гишүүдийг эд хөрөнгийн болон сэтгэл санааны маш их дарамтанд оруулдаг. Тухайлбал ялтны хувьд ногдох хэсгээс төлбөрийг гаргуулахаар ШГА явуулахад тухайн ялтны бусадтай хамтран өмчилж буй хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэн хурааж, худалдан борлуулж хувьд ногдох хэсгийг гаргуулах явцад ялтны гэр бүлийн гишүүдийн эрх ашиг тодорхой хэмжээгээр хөндөгдөж байдаг. Гэтэл гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэж болохгүй, гэмт хэрэгтэн ялыг өөрөө биечлэн эдэлнэ [147] гэсэн Үндсэн хуулийн заалт ноцтой зөрчигдөж байгаа юм.

Жишээ баримт: Чингэлтэй дүүргийн шүүхийн 2012 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 259 дүгээр шийтгэх тогтоолоор Б овогтой О-д 1.345.000 төгрөгийн торгох ял оногдуулжээ. Ялтан О нь 1995 онд төрсөн 17 настай, ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангийн сурагч бөгөөд ээжийнхээ хамт хамаатныхаа айлд амьдардаг, нэн ядуу айл болох нь бас ШГА-ны явцад тогтоогдсон байна.

Дээрх жишээнүүдээс үзэхэд торгуулийн ялын бодлогыг зөв баримтлах нь шүүхийн асуудал боловч цаашид гарах үр дагаврыг анхаарах нь чухал байна. Хорихоос өөр төрлийн ял нь хөнгөн ял гэдэг үндэслэлээр оногддог боловч хэт өндөр торгуулийн ял нь биелэгдэх боломж нөхцлөөр муу байх, биелэгдсэн ч муу үр дагавар ихтэй байх практикт ихээхэн харагдаж байна.

Торгох ялыг эдлүүлэх ажиллагааг гүйцэтгэх, хяналт тавих явцад ялтан төлбөрийн чадваргүй, хөрөнгө орлогогүй зэрэг шалггааны улмаас ихэвчлэн торгох ялын төлбөрийг хэсэгчлэн гүйцэтгэдэг байна. Шүүхийн

[147] Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх заалт

шийдвэр гүйцэтгэх тухай хуульд "Төлбөр төлөгчөөс гаргуулсан эд хөрөнгө, мөнгө нь төлбөрийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй байгаа тохиолдолд төлбөрийг хэсэгчилэн гүйцэтгэх"-ээр [148] мөн төлбөрийн чадваргүй, хөрөнгө орлогогүй тохиолдолд 6 сар хүртэл хугацаагаар хойшлуулах буюу мөн хугацааны дотор хэсэгчлэн гүйцэтгэж[149] болохоор заажээ. Торгуулийн төлбөрийг хэсэгчлэн гүйцэтгэж буй тохиолдлыг авч үзье.

Жишээ баримт: Баянзүрх дүүргийн шүүхийн 2007 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 98 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 155 дугаар зүйлийн 155.2-оор Ө овогтой Ц-д 3.519.000 төгрөгийн торгуулийн ял оногдуулжээ. Ялтан Ц нь бага насны 4 хүүхэдтэй, ажилгүй, өрх толгойлсон эмэгтэй бөгөөд 2007 оны 7 дугаар сард гэр нь шатаж, торгуулийн төлбөрийг төлөх ямар ч бололцоогүй болсон тул торгох ялыг /төлбөрийг/ хэсэгчлэн гүйцэтгэхээр ялтнаар баталгаа гаргуулахад 5000 төгрөгөөс илүү хэмжээгээр төлөх боломжгүй байсны улмаас сард төлөх торгуулийн хэмжээг 5000 төгрөгөөр тогтоосон байна. Энэ тогтоосон хэмжээгээр торгуулийн ялыг 58 жилийн хугацаанд эдэлж дуусгах болж байна.

Ял шийтгүүлсэн ихэнх ялтнууд торгуулийн мөнгийг бага хэмжээгээр төлж болдог гэсэн ойлголттой байдаг. Нөгөө талаар тодорхой хугацааны дараа ялаас чөлөөлөгдөх боломжтой гэсэн ойлголтыг өмгөөлөгч болон бусад этгээдээс авдаг байна.

Ялыг 6 сарын хугацаагаар хойшлуулах буюу мөн хугацааны дотор хэсэгчлэн гүйцэтгүүлэхээр хуульд заасан бөгөөд 6 сарын хугацаанд ялтан торгох ялыг хэсэгчлэн төлөөгүй, торгуулийн төлбөрийг гаргуулах боломжгүй тохиолдолд албадлагын арга хэмжээ эхэлснээс хойш шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн тохиолдолд ялтны үндсэн болон нэмэгдэл ялыг эдлүүлэхгүй ялтныг ялаас чөлөөлөхөөр хуульд заажээ. [150] Энэ нь ял шийтгүүлсэн этгээд ялаас чөлөөлөгдөж, ялын зорилго хангагдахгүй, ял шийтгэл гарцаагүй байх зарчим алдагдаж буй явдал юм.

Монгол Улсын Эрүүгийн хуульд "Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага заавал хүлээлгэнэ" хэмээн заасан байдаг[151]. *Хариуцлага гарцаагүй байх зарчим* бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлж, хүмүүжүүлэхээс гадна бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, санамж өгөх ач холбогдолтой байдаг.[152] *Өөрөөр хэлбэл, энэ нь гэмт хэрэг*

---

[148] УДШ-ийн 2007 оны 43 дугаар тогтоолын 20 дахь хэсэгт"... хэсэгчлэн.; гэдгийг их хэмжээний буюу төлбөрийг нэг мөсөн төлөх чадваргүй этгээдийн эд хөрөнгийн байдалд узлэг хийж, түүнийг эд хөрөнгө, мөнгө нь төлбөрийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй байгаа тохиолдолд тухайн жилд гүйцэтгэж болох ажиллагааны хэмжээг тогтоож болохоор тайлбарласан байна.

[149] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91. 7 дэх заалт

[150] Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт

[151] Эрүүгийн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт

[152] Г. Совд. Эүүгийн хуулийн тайлбар УБ., 2002. 15 дахь тал

үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээд заавал ял эдлэх ёстой бөгөөд үүгээрээ Эрүүгийн хуульд заасан ялын зоришго хангагдаж байх ёстой.

Төлбөрийн чадваргүй, хөрөнгө орлогогүй этгээдэд өндөр хэмжээний торгох ялыг шүүхээс оногдуулж байгаа явдал нь дээрх зарчмыг алдагдахад хүргэж байна.

Ялтан торгуул төлөх эд хөрөнгийн боломжтой атлаа эд хөрөнгө, цалин орлогоо нуух, бусдад хууль бусаар шилжүүлэх, үрэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүй байнга оршин суугаа газраа дур мэдэн өөрчлөх, зориуд оргон зайлах зэрэг бусад санаатай нөхцөл байдлуудыг ялаас зайлсхийх хэмээх ойлголтонд хамааруулан ойлгодог. Тэгвэл төлбөрөө төлөхгүй бага хэмжээгээр төлж буй байдлыг ялаас зайлсхийж байна гэж үзэж болохгүй, ялаас зайлсхийсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч зохих шалгаж явуулж /Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай хууль зүйн ойлголт байхгүй учир/ Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1-д зааснаар хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч 3 жил өнгөрсөн бол ялаас чөлөөлөх үндэслэл болдог. Энэ заалт нь зөвхөн торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэхэд хэрэглэгдэх бөгөөд торгуулийн ялын төлбөрийг төлөх төлбөрийн чадваргүй гэдгийг хууль зүйн үндэслэлтэйгээр нотолж бүрдүүлсэн баримт, хувийн хэргийн хамт харьяа прокурорт танилцуулан ял солих санал гаргаж, прокурорын дүгнэлт гаргуулж, шүүхэд хүргүүлдэг.

ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэдэг нь иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, шүүхээс баталгаажуулж өгсөн бусад байгууллагын шийдвэр, хорихоос өөр төрлийн ял оногдуулахаар заасан шүүхийн шийтгэх тогтоол, тэдгээрийг үндэслэн төрөөс хуулиар олгогдсон эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гүйцэтгэж байгаа төрийн албадлагын арга хэмжээний нэг төрөл юм.

Торгох ял, ялын оногдуулалт болон хэрэгжилт, Шүүхийн ШГА, ажиллагааны тухай ерөнхий ойлголт, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарвал зохих асуудлын хүрээнд торгох ялыг биелүүлэх ШГА-г явуулах явцад гарч байгаа хүндрэл бэрхшээл нилээдгүй байна. Тухайлбал:

-Ялтан этгээдүүд торгох ялыг ял гэхээсээ илүү төлбөр гэж ойлгож ханддаг тул биелэлт нь удаан, хойрго байна.

-Шүүх шийтгэх тогтоол, гүйцэтгэх хуудсыг хуулийн хугацаанд нь шийдвэр гүйцэтгэх албанд шуурхай хүргүүлдэггүй. Энэ нь ялтнууд хяналтад орохгүй оргон зайлах, оршин суугаа хаягаа өөрчлөх, хөрөнгөө нуух, бусдад шилжүүлэх зэрэг хүндрэлтэй нөхцөл байдал гаргадаг.

-Шүүхээс төлбөрийн чадваргүй, өөрийн гэсэн өмч хөрөнгөгүй, ажил хөдөлмөр эрхэлдэггүй, тодорхой орлогогүй этгээдэд өндөр торгуулын ял

оногдуулж байгаа нь ял биелэгдэхгүй байх нэг шалтгаан болдог.

-Мөн Шүүхийн өмнөх шатанд өөрөөр хэлбэл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд эд хөрөнгө хурааж, битүүмжлэх, хөрөнгө хамгаалах ажиллагааг хангалтгүй дутуу хийгдсэн байдаг. Шүүх шийтгэх тогтоолыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлэхдээ хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд тухайн этгээдийн эд хөрөнгийг хамгаалсан, битүүмжилсэн тогтоол материалыг хамт хүргүүлдэггүй нь ШГА явуулахад хүндрэл үүсгэж, хэрэг материалаас тогтоолыг нь дахин авах болон дахин эхнээс нь ажиллагаа хийх зэргээр хугацаа их алддаг байна.

-Өмгөөлөгч нар Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлд зааснаар "Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч гурван жил өнгөрсөн бол ялаас чөлөөлөх" гэснийг төлбөрийг багаар төлсөөр 3 жил өнгөрөхөд ялыг нь хэрэгсэхгүй болгодог гэж буруу тайлбарлан ойлгуулдаг байна.

-Торгох ялтай этгээдийн ялыг солиулахаар прокурор тогтоол бичиж шүүхэд шилжүүлсэн тохиолдолд шүүх ялаас ноцтой зайлсхийсэн гэдгийг тогтоохыг шаардаж шийдвэрлэхгүй буцаах тохиолдол гардаг.

-Шүүх шийтгэх тогтоолыг биелүүлэхтэй холбоотой асуудлыг тодорхой хугацаагүй удаан шийдвэрлэдэг зэрэг хүндрэл бэрхшээлүүд байгаа юм.

Иймд дээрх байдлуудаас дүгнэлт хийж үзэхэд:

-Торгох ялыг төлбөрийн чадвартай ялтанд оногдуулах шаардлагатай бөгөөд ***торгуулийн хэмжээ өндөр байхдаа гол бус, харин ял шийтгэлийн биелэлт гарцаагүй байх нь хамгийн чухал юм.***

-Монгол Улсад торгох ялын биелэлтийг бүрэн дүүрэн хангах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд зохих хууль тогтоомжийн заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай юм.

-Мөн Прокурорын байгууллагын болон ШГГ-ын торгох ялын биелэлтэнд хяналт тавих ажиллагааг сайжруулах явдал юм.

-Энэ ялын хэрэгжилтийг хангах талаарх бодлого, онол-практикийн үндэслэлийг эрэлхийсэн эрдэмтэн, судлаачдын судалгаа шинжилгээний бүтээл, ном ховор байх тул энэ чиглэлд анхаарал хандуулан ажиллах, нарийвчлан судалгаа шинжилгээ хийх зайлшгүй хэрэгцээ байна.

-Даяарчлагдаж буй өнөө цаг үед хууль сахиулах байгууллагууд хоорондын болон тэдгээрээс бусад байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, дэмжлэг туслалцаа үзүүлэх, ялын хэрэгжилтийг хангах асуудал зөвхөн ШГГ, шийдвэр гүйцэтгэгч нарын асуудал буй хууль хяналтын байгууллага бүрийн үүрэг юм.

САНАЛ

Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төлбөрийн чадвар, амьжиргааны эх үүсвэр орлого, эд хөрөнгө, оршин суух хаяг зэргийг баталгаатай тогтоосны, мөн байцаан шийтгэх ажиллагааны явцад эд хөрөнгө тогтоох, хамгаалах ажлыг зохион

байгуулалттайгаар хэрэгжүүлж хамгаалсны үндсэн дээр торгох ялыг оногдуулж байх нь ялын хэрэгжилтэнд зохих үр дүнгээ өгөх талтай. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр, тогтоолыг цаашид гаргахдаа хуулийг тайлбарлах, хууль хэрэглээний асуудал, шүүхийн шийдвэрийн хууль зүйн үр нөлөө, ач холбогдлыг нэмэгдүүлж илүү шинжлэх ухааны шинж чанарыг түлхүү анхаарах нь зүйтэй юм.

-Өнөөдөр шүүх торгох ялыг оновчтой зөв сонгон хэрэглэж чадахгүй байгаагаас ялын биелэлтийг хангаж чадахгүйд хүрч байна. Иймд шүүхээс хууль дахь хүнд төрлийн ял, хөнгөн төрлийн ялын аль нэгийг сонгон оногдуулахаар заасан зохицуулалтыг өөрчлөн хуульд заасан ялын төрлөөс чөлөөтэй сонгон оногдуулах боломжийг хуулиар олгох нь зүйтэй.

-Ял шийтгүүлэх гэж буй гэмт хэрэгтэн хэрвээ хорих ялаар шийтгүүлбэл нийгмээс тусгаарлагдах төдийгүй давтан гэмт хэрэгтнүүдтэй хамт байснаар тэдний зүгээс нөлөөлж болох ёс зүй, зан төрх, хүмүүжлийн муу нөлөөнд автах болзошгүй байдаг. Тэгвэл торгох ял нь дээрх сөрөг үр дагавраас сэргийлдэг сайн талтай. Иймээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр, гэр орондоо, ойр төрлийн хүмүүсийнхээ дэргэд улмаар тодорхой хамт олны дунд байлгаж, тэдгээрийн дэмжлэг нөлөөн дор гэм буруугаа ойлгож, амьдралын зөв байр суурь хандлага руугаа эргэн орох боломжийг хууль хяналт, төр захиргааны болон ял эдлүүлэх байгууллага анхааралдаа авч шийдвэрлэх нь чухал байна.

Иймд торгох ялыг ял шийтгүүлэгчдийн хөдөлмөрийн хөлс, цалин бусад орлогын зохих хувь эсвэл өдөрт олж болох орлогын хэмжээгээр тогтоох нь илүү үр дүнтэй байж болох талтай юм.

Торгох ялын үндсэн агуулга нь нэг талаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих ялыг хэрэглэхгүйгээр эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хэрэгжүүлэх нөгөө талаас ял шийтгүүлсэн этгээдэд эд материалын хохирол учруулж цээрлэл үзүүлэхэд чиглэгдэх ёстой.

-Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1-д "хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч гурван жил өнгөрсөн" гэсэн заалтыг "хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч нэг жил өнгөрсөн" гэж хугацааг багасгасан өөрчлөлт оруулж тусгах шаардлага үүсч байна. Учир нь 3 жилийн хугацаанд ялын хэрэгжилт, ач холбогдлоо өгөх тал дээр дутагдалтай байдаг. Ингэж хуулийн заалтыг өөрчилснөөр торгох ял жинхэнэ утгаараа бүрэн биелэгдэх болон хэрэв хөрөнгө орлогогүй нь нотлогдох юм бол 3 жилийн хугацаагаар сунжрахгүй 1 жил болоод ялаас чөлөөлөгдөх бөгөөд он дамжсан үлдэгдэлгүй байх

-Мөн хуулинд хөрөнгө, орлого байхгүй, ажил хийдэггүй ялтнаар нийгэмд тустай ажил хийлгэж, олсон орлогоос нь төлбөрийг төлүүлэх талаар зохицуулалт нэмж оруулах

-ШГА-ны шуурхай байдлыг хангах үүднээс холбогдох албан тушаалтнуудаас хуулийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн

санд нэвтэрч үйл ажиллагаандаа ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх

-Өнөөгийн ШГГ-ын тогтолцоо, ШГА-г явуулж буй үйл ажиллагаа нь бодит байдлаас харахад хуулийн дагуу хараат бус явагдаж байгаа эсэхэд зарим талдаа учир дутагдалтай байна.

Ю.ОТГОНЖАРГАЛ
Сүхбаатар дүүргийн
157-р тойргийн
шийдвэр гүйцэтгэгч

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС ТӨЛБӨР ГАРГУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор "Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийг баталж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд чиглэсэн хуулиудыг батлан гаргасан билээ.

МУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2002 оны хууль нь өмнө дагаж мөрдөж байсан хуулиудаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар илүү нарийвчилсан хэдий ч хуулийг хэрэгжүүлэх явцад төрийн байгууллагаас төлбөр гаргуулахтай холбоотой шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд зарим нэг хүндрэл тулгарч байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж байгаа хүний хувьд энэ чиглэлээр эрдэм шинжилгээний ажил хийж өөрийн хувь нэмрээ оруулах үүднээс уг сэдвийг сонгон авч судаллаа.

Энэхүү илтгэлийн хүрээнд төрийн байгууллагаас төлбөр гаргуулах ажиллагааны ойлголт, онцлог, түүний эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг онол, практикын талаас нь